ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Орхон аймгийн Одод цэцэрлэг
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/91/СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Орхон аймаг<br>2021 он | Орхон аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Нармандах<br>Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn<br>Аудитын менежер:Б.Эрдэнэ<br>Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитор: Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: www.dalaivanaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....0
3.Аудитын тайлан ....3
3.1. Ерөнхий зүйл ....3
3.1. Ерөнхий зүйл ....3
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....3
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....4
3.4. Материаллаг байдал ....4
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....4
3.7. Шилэн дансны мэдээлэл ....6
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....6
3.9. Аудитын илрүүлэлт....7
**Залруулсан алдаа**....7
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....7
Аудитын зөвлөмж....7
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....7
4. Менежментийн захидал ....7

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Хандоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 38
танай ______ -ны № ______ -т

ОРХОН АЙМГИЙН ОДОД ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Одод цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Одод цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **42,228,563.25** | **39,412,183.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 389,723.46 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 389,723.46 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 41,838,839.79 | 39,412,183.63 |
| **351** | **Түүхий эд материал** | 40,099,379.79 | 37,633,738.63 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 40,099,379.79 | 37,633,738.63 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,739,460.00 | 1,778,445.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | - | 335,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 545,510.00 | 989,445.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,193,950.00 | 454,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,516,087,962.11** | **1,480,066,479.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,516,087,962.11 | 1,480,066,479.43 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,334,362,962.08 | 1,298,441,479.36 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,324,717,144.95 | 1,324,717,144.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,597,422.32) | (62,198,294.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,218,247.00 | 44,466,747.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,660,345.45) | (29,863,169.89) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,662,860.06 | 53,662,860.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,977,522.16) | (32,343,808.16) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 181,725,000.03 | 181,625,000.07 |
| 39301 | Программ хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (74,999.97) | (174,999.93) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 181,400,000.00 | 181,400,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,558,316,525.36** | **1,519,478,663.06** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,558,316,525.36** | **1,519,478,663.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,558,316,525.36 | 1,519,478,663.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 181,400,000.00 | 181,400,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 618,030,751.17 | 579,192,888.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 618,030,751.17 | 618,030,751.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (38,837,862.30) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 758,885,774.19 | 758,885,774.19 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | | |
| 51600 | Нөөцийн сан | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,558,316,525.36** | **1,519,478,663.06** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **651,978,050.00** | **401,125,250.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **274,550,250.00** | **10,801,350.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 69,104,850.00 | 10,801,350.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 69,104,850.00 | 10,801,350.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 69,104,850.00 | 10,801,350.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 205,445,400.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 205,445,400.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **377,427,800.00** | **390,323,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 308,021,700.00 | 361,144,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 308,021,700.00 | 361,144,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 42,839,200.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 167,400.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 400,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,104,400.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 167,400.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,566,900.00 | 29,179,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,566,900.00 | 29,179,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **421,262,241.95** | **436,512,571.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **421,262,241.95** | **436,512,571.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 420,162,241.95 | 431,150,674.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,737,300.00 | 292,848,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 206,453,120.00 | 221,632,532.00 |
| 210102 | Нэмэгдэл | 34,382,787.00 | 47,615,936.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 1,246,800.00 |
| 210104 | Урамшуулал | 22,901,393.00 | 22,353,532.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,015,776.54 | 37,654,423.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,615,771.08 | 26,020,423.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,621,487.83 | 2,908,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,097,190.27 | 2,326,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 516,484.34 | 581,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,164,843.02 | 5,817,000.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,875,500.00 | 24,002,452.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,796,771.73 | 2,611,941.42 |
| 210302 | Түлш, халаалт | 15,647,056.49 | 15,846,111.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,431,671.78 | 5,544,399.87 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,200,400.00 | 8,459,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 761,400.00 | 96,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 166,200.00 | 78,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 60,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 61,600.00 | 5,971,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,211,200.00 | 2,252,550.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,935,490.00 | 20,296,915.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,800.00 | 150,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,794,190.00 | 20,146,315.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 113,500.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,291,400.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,291,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 243,600.00 | 1,138,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 243,600.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,862,775.41 | 46,750,482.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 216,000.00 | 220,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,238,400.00 | 5,260,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,408,375.41 | 41,269,982.68 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,100,000.00 | 5,361,897.10 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,100,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 5,361,897.10 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,361,897.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **230,715,808.05** | **(35,387,321.14)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 11,198,676.84 | 3,450,541.16 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 11,198,676.84 | 3,450,541.16 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (11,198,676.84) | (3,450,541.16) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **219,517,131.21** | **(38,837,862.30)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **604,146,213.00** | **395,366,321.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **220,575,900.00** | **-** |
| **122** | **Тусламжийн орлого** | 15,130,500.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 15,130,500.00 | |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | | |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 205,445,400.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 205,445,400.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **383,570,313.00** | **395,366,321.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 308,021,700.00 | 361,144,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 308,021,700.00 | 361,144,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 42,839,200.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 167,400.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 400,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,104,400.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 167,400.00 | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,566,900.00 | 29,179,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,566,900.00 | 29,179,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 6,142,513.00 | 5,042,421.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 6,142,513.00 | 5,042,421.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **383,002,913.00** | **395,366,321.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **383,002,913.00** | **395,366,321.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **375,760,400.00** | **384,962,002.90** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,737,300.00 | 292,848,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 223,031,877.00 | 190,523,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,314,792.00 | 77,487,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,160,000.00 |
| 210104 | Урамшуулал | 11,390,631.00 | 22,678,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,405,500.00 | 37,264,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,241,600.00 | 25,630,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,291,000.00 | 2,908,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,832,800.00 | 2,326,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 458,200.00 | 581,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,581,900.00 | 5,817,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,875,500.00 | 24,002,452.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,078,150.00 | 2,611,941.42 |
| 210302 | Түлш, халаалт | 14,570,950.00 | 15,846,111.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,226,400.00 | 5,544,399.87 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 963,100.00 | 6,513,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 570,900.00 | 96,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 166,200.00 | 78,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 60,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 61,600.00 | 6,103,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 164,400.00 | 174,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 49,794,600.00 | 21,274,650.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,800.00 | 150,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 47,339,700.00 | 20,590,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,427,100.00 | 533,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,291,400.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,291,400.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 243,600.00 | 1,138,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 243,600.00 | 1,008,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,449,400.00 | 1,920,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 216,000.00 | 220,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,233,400.00 | 1,700,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,242,513.00** | **10,404,318.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,242,513.00 | 5,042,421.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 6,142,513.00 | 5,042,421.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,100,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 5,361,897.10 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,361,897.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **221,143,300.00** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **400,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **400,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 400,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 400,000.00 | - |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(400,000.00)** | **-** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 220,743,300.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 220,743,300.00 | - |

CT-4A

# ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 181,400,000.00 | 758,885,774.19 | 604,126,419.96 | | 1,544,412,194.15 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **181,400,000.00** | **758,885,774.19** | **604,126,419.96** | **-** | 1,544,412,194.15 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 13,904,331.21 | | 13,904,331.21 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **181,400,000.00** | **758,885,774.19** | **618,030,751.17** | **-** | 1,558,316,525.36 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **181,400,000.00** | **758,885,774.19** | **618,030,751.17** | **-** | 1,558,316,525.36 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **181,400,000.00** | **758,885,774.19** | **618,030,751.17** | **-** | 1,558,316,525.36 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (38,837,862.30) | | (38,837,862.30) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **181,400,000.00** | **758,885,774.19** | **579,192,888.87** | **-** | 1,519,478,663.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | 383002913.00 | 390323900.00 | 384962002.90 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | 383002913.00 | 390323900.00 | 384962002.90 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 375760400.00 | 390323900.00 | 384962002.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 263737300.00 | 292848800.00 | 292848800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 223031877.00 | 190523100.00 | 190523100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 29314792.00 | 77487200.00 | 77487200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 | 2160000.00 | 2160000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 11390631.00 | 22678500.00 | 22678500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 33405500.00 | 37264700.00 | 37264700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 24241600.00 | 25630700.00 | 25630700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 2291000.00 | 2908500.00 | 2908500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 1832800.00 | 2326800.00 | 2326800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 458200.00 | 581700.00 | 581700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 4581900.00 | 5817000.00 | 5817000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 24875500.00 | 28037000.00 | 24002452.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 4078150.00 | 2783800.00 | 2611941.42 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 14570950.00 | 15744300.00 | 15846111.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 6226400.00 | 9508900.00 | 5544399.87 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 963100.00 | 6513100.00 | 6513100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 570900.00 | 96700.00 | 96700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 166,200.00 | 78,300.00 | 78,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - | 60,500.00 | 60,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 61,600.00 | 6,103,500.00 | 6,103,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 164,400.00 | 174,100.00 | 174,100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | - | 49,794,600.00 | 21,274,700.00 | 21,274,650.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 27,800.00 | 150,600.00 | 150,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 47,339,700.00 | 20,590,300.00 | 20,590,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,427,100.00 | 533,800.00 | 533,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,291,400.00 | 1,142,100.00 | - |
| 210604 | Урсгал засвар | - | 1,291,400.00 | 1,142,100.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - | 98,800.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | - | - | 98,800.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 243,600.00 | 1,138,000.00 | 1,138,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | - | 130,000.00 | 130,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 243,600.00 | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,449,400.00 | 2,006,700.00 | 1,920,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 216,000.00 | 306,400.00 | 220,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,233,400.00 | 1,700,300.00 | 1,700,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 7,242,513.00 | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 7,242,513.00 | - | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 6,142,513.00 | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,100,000.00 | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 355,861,613.00 | 390,323,900.00 | 390,323,900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 308,021,700.00 | 361,144,800.00 | 361,144,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 308,021,700.00 | 361,144,800.00 | 361,144,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 26,566,900.00 | 29,179,100.00 | 29,179,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 26,566,900.00 | 29,179,100.00 | 29,179,100.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 6,142,513.00 | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 6,142,513.00 | - | - |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | - | 15,130,500.00 | - | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 15,130,500.00 | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | - | - | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | - | - | 27.50 | 27.50 |
| 620001 | Удирдах ажилтан | - | - | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | - | 17.00 | 17.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | - | 9.50 | 9.50 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | - | - | 1.00 | 1.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | - | - | 1.00 | 1.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | - | - | 1.00 | 1.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **-** | **-** | **27.50** | **27.50** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | - | - | 15.00 | 15.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | - | - | 12.50 | 12.50 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Одод цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Одод цэцэрлэгийн эрхлэгч Б.Энхцэцэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12-р сарын 09-нас 2021 оны 02-р сарын 12–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02-р сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “ Бэйкер Тилли Далайван аудит ” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн , аудиторын туслах Б.Энхжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Одод цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01-р сарын 14-ны өдрийн 1 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хүүхдээ дээдлэн, багшаа хөгжүүлэх, хүүхэд бүрийн хэрэгцээ , сонирхолд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэн, чанартай сургалт явуулахад оршино.

Орхон аймгийн Одод цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Одод цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймаг дахь Санхүү хяналт, аудитын алба 2020 онд Орхон аймгийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн Одод цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “ Дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг санхүүгийн тайлангийн 2-р улирлын тайлангийн нийт орлого болох 228,837.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,288.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үеийн үзүүлэлтээр болох нийт орлого 401,125.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,011.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон аймгийн Одод цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,837.86 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 389.72 | 0 | -389.72 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 41,838.84 | 39,412.18 | -2,426.66 |
| Үндсэн хөрөнгө | 1,516,087.96 | 1,480,066.48 | -36,021.48 |
| **Нийт хөрөнгө** | **1,558,316.53** | **1,519,478.66** | **-38,837.86** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,558,316.53 | 1,519,478.66 | -38,837.86 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,558,316.53** | **1,519,478.66** | **-38,837.86** |

Тайланд оны эцсээр авлага, өр төлбөргүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,412.2 мянган төгрөг болж 2,426.66 мянган төгрөгөөр буурсан. Бараа материалын дансанд Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн төвөөс 2020 оны 04-р сарын 22-ны өдрийн 458/8 дугаар тушаал бүхий 819.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал , үнэ төлбөргүй эцэг эхээс авдаг бусад хангамжийн материал болох 4,732.95 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Бараа материалын данснаас 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн №57 дугаар бүхий 3,450.54 мянган төгрөгийн бараа материал акталсан. Мөн Боловсрол , шинжлэх ухааны яамны сайдын 2020 оны 11-р сарын 27-ны өдрийн А/162 дугаар бүхий тушаалаар 513.84 мянган төгрөгийн хүнсний материалыг Орхон аймгийн Ондгой байдлын газарт өгсөн байна.

| | 2019.12.31 | 2020.12.31 | Зөрүү | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтай материал | 40,099.38 | 37,633.74 | -2,465.64 | -5.89 |
| Аж ахуйн материал | 0 | 335.0 | 335.0 | 0.8 |
| Хүнсний материал | 545.51 | 989.44 | 443.93 | 1.06 |
| Бусад хангамжийн материал | 1,193.95 | 454.0 | -739.95 | -1.77 |
| Нийт дүн | 41,838.84 | 39,412.18 | -2,426.66 | -5.8 % |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,480,066.48 мянган төгрөг болж 36,021.48 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна. Боловсролын яамнаас 2020 оны 08-р сарын 20-ны өдрийн БМЗ-537 дугаар бүхий зарлагын баримтыг үндэслэн 5,248.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжин ирсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,519,478,66 мянган төгрөг болж 38,837.86 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Одод цэцэрлэг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 265,983.3 мянган төгрөгөөр буюу 39.87 хувиар буурсан бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос буурснаас шалтгаалсан байна. Харин төсвийн санхүүжилтийн орлого 53,123.1 мянган төгрөгөөр өссөн байна.

| | **2019.12.31** | **2020.12.31** | **Зөрүү** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|---|
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 289,680.75 | 10,801.35 | -278,879.4 | - 41,80 |
| Урсгал санхүүжилт | 308,021.7 | 361,144.8 | 53,123.1 | 7,96 |
| Нэмэлт санхүүжилт | 69,406.1 | 29,179.1 | -40,227.0 | - 6,03 |
| **Нийт дүн** | 667,108.55 | 401,125.25 | -265,983.3 | 39,87 % |

Нийт зардал өмнөх оноос 15,250.33 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс 29,111.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,638.65 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 5,259.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 894.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 390,323.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 361,144.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 29,179.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 361,144.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29,179.1 төгрөгийн, нийт 390,323.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 384,962.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,361.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу төсвийн хэмнэлт үүссэн нь Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдсантай холбоотой байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,034.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 1,142.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 86.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 98.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй бөгөөд зарцуулалт хийгээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд иж бүрэн бус мэдээлсэн байна. Хугацаа хоцорсон шалтгаан нь 1-р сарын Төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийн хугацааг хоцроон байршуулсан болно.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 589.4 | 1 | 589.4 | 1 | 589.4 | 100 |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 3 | 2,662.24 | 3 | 2,662.24 | 3 | 2,662.24 | 100 |
| Нийт дүн | 4 | 3,251.64 | 4 | 3,251.64 | 4 | 3,251.64 | 100 |

Тухайн байгууллага нь тухайн биелэлтийг 2020 оны 06-р сарын 16-ны өдрийн №26 тоотоор хариу тайлбар ирүүлэн ажилласан байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,840.24 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,165.65 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоож, 14,674.59 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах,давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залруулга үүсээгүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 17,840.24 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, 3,165.65 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

Нийт албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхцуулан цалингийн зардлын хэмнэлтээс албан хаагч бүрд 115.1 мянган төгрөг, нийт 3,165.65 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 14,674.59 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Цалинтай холбоотой тушаал болон нэмэгдэл, суутгал дээр анхааран үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1.*<u>Зардлын данстай холбоотой асуудал</u>***

1.1. *<u>Илрүүлэлт:</u>* Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг буруу оруулсныг залруулснаар хугацаа

Орхон аймгийн Одод цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хоцроож, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна. Хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байх 14,600.0 мянган төгрөгийн худалдан авалтыг дутуу мэдээлснийг залруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. *<u>Эрсдэл:</u>* Мэдээлэл хэрэглэгчийн буруу мэдээллээр хангах, төсвийн ил тод байдал хангагдахгүй байх.

1.3. *<u>Өгсөн зөвлөмж:</u>* Шилэн дансны тухай хууль, журмын дагуу мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, дотоод хяналт хэрэгжүүлэх.

*<u>1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн № 09 тоот албан тоотоор хариу ирүүлсэн.

**2.*<u>Зардлын данстай холбоотой асуудал</u>***

*<u>2.1. Илрүүлэлт:</u>* ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн эцэст өссөн дүнгээр залруулж тохируулга хийгээгүй, 74 590 төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

*<u>2.2. Эрсдэл:</u>* Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх

*<u>2.3. Өгсөн зөвлөмж:</u>* Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.14."Албан татварын хөнгөлөлтийг энэ хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй бөгөөд энэ хуулийн 23.1, 23.9-д заасн аас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно" гэсэн заалтын дагуу тохируулга хийж тайлагнах,

*<u>2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн № 09 тоот албан тоотоор хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>**

Бэлтгэсэн:

Аудитор [signature] Б.Пүрэвсүрэн Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер [signature] Б.Эрдэнэ Огноо 2021.01.28

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор [signature] Ц.Нармандах Огноо

6117143693
ФАА2073 9042936

ОРА-2021/91/СТА-ТШЗ